



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 8/176

Бат-Өлзий сум

Шууд гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаан ам багийн Хөнөгт малын тарилгын хашаа барих ажлыг 1 дүгээр багийн иргэн С.Бямбатөмөр, Өвт багийн Мойлтод булагийн эх хаших, Их Мойлтод малын тарилгын хашаа барих ажлыг 3 дугаар багийн иргэн Д.Ганзориг, Зөрүүлэг багийн Нарийн, Онгоцот малын тарилгын хашаа барих ажлыг 4 дүгээр багийн иргэн Ц.Чинбаяр, Улиастай багийн Цагаан азарга, Шивэртий, Хурц, Улиастай дэнж, Бөөрөгт малын тарилгын хашаа барих ажлыг 6 дугаар багийн иргэн Д.Дорждагва, Хүйтэн булагийн Мухар хустын булагийг хаших ажлыг 5 дугаар багийн иргэн Б.Баянжаргал нартай шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгүүлсүгэй.

2. Дээрх иргэдтэй гэрээ байгуулж, ашиглалтын явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Хөнөгт малын тарилгын хашаа барих ажлыг 2,000,000 (хоёр сая) төгрөг, Өвт багийн Мойлтод булгийн эх хаших ажлыг 2,000,000 (хоёр сая) төгрөг, Их Мойлтод малын тарилгын хашаа барих ажлыг 2,000,000 (хоёр сая) төгрөг, Зөрүүлэг багийн Нарийн, Онгоцот малын тарилгын хашаа барих ажлыг 4,000,000 (дөрвөн сая) төгрөг, Улиастай багийн Цагаан азарга, Шивэртий, Хурц, Улиастай дэнж, Бөөрөгт малын тарилгын хашаа барих ажлыг 5,000,000 (таван сая) төгрөг, Хүйтэн булагийн Мухар хустын булагийг хаших ажлыг 2,000,000 (хоёр сая) төгрөг, зардалд шаардагдах нийт 17,000,000 (арван долоон сая) төгрөгийг гэрээний дагуу зарцуулахыг Санхүүгийн албаны нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

4. Санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН